

Монгол орны “Жонш”-оор нэрлэсэн газар, тэдгээрийн
байршил, нэрийн агуулга

Ж. Нарангарав*

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа өөрийн хүрээлэн буй байгаль орчны биетүүдийг нэрлэж, өөр хооронд нь ялгаж ирсэн билээ. Өвөг дээдсийхээ газар нутгаа нэрлэж байсан байдлыг ажиглахад хаана, ямар зүйл элбэг түүгээр нь тухайн газарзүйн биетийг нэрлэдэг байсан нь илэрхий ажиглагдаж байгаа бөгөөд энэ байдал нь ашигт малтмал, амьтан, ургамал зэргээр нэрлэсэн газруудад илүү тод харагдана.

Эрдэмтэн зохиолч Л. Түдэв монгол газар нутгийн нэрийг судлахын чухлыг тэмдэглэхдээ: “Газрын нэр гэдэг бол түүх, газар зүй, угсаатан судлал, хэл шинжлэл, олон улсын харилцаа, тэр ч байтугай геологи хайгуулын шинжлэх ухаанд онцгой тус болох өвөрмөц онц дохио юм. Иймээс нэр судлал анхаарал татахгүй үлдэх ёсгүй. Эрдэнэтийн овоо, Төмөртийн уул, Оюу толгой гэх мэтийн монгол нэртэй газруудад одоо томоохон уурхайн ажил өрнөж байгааг бодоод үзэхэд илүүдэх юун!” гэжээ.¹ О. Сүхбаатар “Монголын газар усны нэр мэдээлэлийн сан болох нь” өгүүлдэдээ “Ер нь нүүдэлчдэд газрыг үзэгч шинжигч билгийн нүдэт, бурхдын бясалгалт тусгай хүмүүн байсан байна” гэж профессор Л. Хүрэлбаатар үзжээ. Мэдээж билгийн нүдэт тэдгээр үзэгч, шинжигч нар газрын тогтоц, байрлалыг нарийн үзэж, ямар ан амьтан ишвээлдэг, ямар өвс ургамал ургадаг, ямар түүхэн үйл явдал болж өнгөрсөн, ямар эрдэс баялагтай, түүнтэй нь холбон нэр өгөх өвөрмөц хэлбэр лүү шилжсэн нь өнөөгийн бидэнд уламжлагдан иржээ” гэжээ.² Э.Равдан өөрийн хариуцан эрхэлж эмхтгэсэн “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь”³-оосоо дараах ашигт малтмалын нэрийг түүвэрлэн, аймаг, сумаар нь нягталж, уг хэлхээг Монгол улсын ШУА-ын Газарзүйн хүрээлэнтэй хамтран гүйцэтгэх “Монгол орны эрдэс баялагийн нэрийн атлас” бүтээлд оруулахаар дээрх хүрээлэнд 2005 онд хүлээлгэн өгчээ. Үүнд :

* Монгол Улсын Их Сургууль, Гадаад хэл, Соёлын Сургууль.

¹ Л.Түдэв, “Газрын нэр судлалын шинэ ололт”, Дал сонин, 2005, 205/51

² О.Сүхбаатар, “Монгол газар усны нэр мэдээлэлийн сан болох нь”, Mongolica. Vol 14(35) УБ., 2004, 203-р тал

³ “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь” (Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан /1970-1980/, 5 боть, 8 дэвтэр), УБ., 2005

Металл:

Алт, алтан, алтат	493	Тугалга	8
Гууль, гуульт	7	Хүрэл	153
Мөнгө, мөнгөт	163	Цайр	1
Зэс	37	Цахиур, цахиуртын	352
Төмөр, төмөртийн	153		

Металл биш:

Алмаз	1	Нүүрс, нүүрстийн	47
Биндэрья	7	Оюу, оюут	72
Болор, болорт	11	Тана, танат	7
Боржин, боржингийн	25	Тос, тост	321
Гантиг, гантигт	4	Хаш, хашт	14
Дарь, дарьт	47	Хүдэр, хүдэрийн	32
Жонш, жоншт	72	Ширэм, ширэмт	2
Зос, зостын	280	Шохой, шохойт	75
Мана, манат	47	Шүр, шүрт	45
Молор, молорт	7	Цайр	1
Номин, номингийн	23	Эрдэнэ, эрдэнэт	333

Уг хэлхээнд ашигт малтмал, эрдэс баялгаар нэрлэсэн нийт 2674 газар нутгийн нэр бүртгэгдсэн байна. Эдгээр нэрийг бүгдийг нь судлахад ганц энэ ажлын хүрээнд багтахгүй тул энд зөвхөн “жонш”-оор нэрлэсэн газар нутгийн нэрийг сонгон авч, нарийвчлан үзэв. Уг ажлын гол зорилго нь “жонш” –оор нэрлэсэн газар нутгийн нэр, уг газрын жонштойг заасан эсэхийг тогтоох явдал болно. Өөрөөр хэлбэл, газар нутгийн нэрийн агуулгыг нээх явдал юм.

Жонш гэдэг нь Са, F хоёрын нэгдэл бөгөөд энэ ашигт малтмал нь 15-р зууныг хүртэл өөрийн гэсэн нэргүй байжээ. Түүний хайламтгай болоод металлын хайлалтыг түргэгсгэдэг чанар зэргийг нь харгалзан хайлуур жонш хэмээн нэрлэсэн бөгөөд латинаар флюорит, монголчилбол “урсамтгай” гэсэн утгатай юм. Жонш нь тунгалаг, цагаан, ягаан, ногоон, шар, хүрэвтэр өнгө бүхий талстнаас бүрдсэн бутрамтгай, металл биш ашигт малтмал юм.

Манай орон хайлуур жоншоор баялаг бөгөөд эрдэмтэд жоншны 3 том бүс байгааг тогтоожээ. Үүнд :

1. нутгийн хойд хэсгийн бүс
2. нутгийг хөндлөн дайран гарсан бүс
3. нутгийн өмнөд хэсгийн бүс юм.

Уг гурван бүсээс хоёр дахь буюу нутгийг хөндлөн дайран гарсан бүс нь нөгөө бүсүүдээсээ нөөцөөрөө илүү бөгөөд ашиглалт ч эрчимтэй хийгдэж байгаа билээ. Энэ тухай өгүүлэхдээ бид Монгол Оросын хамтарсан Монголросцветмет нэгдлээс гаргасан мэдээ баримт, бусад зүйлсийг ашиглав.⁴ Манай оронд жоншоор нэрлэгдэж, бүртгэгдсэн нийт 72 газар байна.

⁴ “Монголросцветмет нэгдэл” 25 жилийн ойд, УБ., 1998, “Монголросцветмет нэгдэл” 30 жилийн ойд, УБ., 2003


Монгол улс дахь жонш бүхий нэртэй газар

Монгол нэр	Галиг нэр	Аймаг	Сум
Жонш ам	Jonsh am	Завхан	Булнай
Жоншийн ам	Jonshyn am	Баянхонгор	Гурванбулаг
Жоншт ам	Jonsht am	Завхан	Отгон
Жоншт ам	Jonsht am	Говь-Алтай	Цогт
Жоншт ам	Jonsht am	Архангай	Хангай
Жонштын ам	Jonshtyn am	Ховд	Буянт
Жонштын ам	Jonshtyn am	Говь-Алтай	Эрдэнэ
Жонштын ам	Jonshtyn am	Хөвсгөл	Жаргалант
Урд Жонш ам	Urd Jonsh am	Говь-Алтай	Дэлгэр
Хойд Жонш ам	HoYd Jonsh am	Говь-Алтай	Дэлгэр
Жонш уул	Jonsh uul	Завхан	Булнай
Жоншийн Тавцан уул	Jonshyn Tavtsan uul	Баянхонгор	Баянбулаг
Жоншны Товгор уул	Jonshny Tovgor uul	Хөвсгөл	Тариалан
Жоншны Товгор уул	Jonshny Tovgor uul	Булган	Тэшиг
Жоншт Овоо уул	Jonsht Ovoo uul	Өвөрхангай	Өлзийт
Жоншт уул	Jonsht uul	Өвөрхангай	Нарийнтээл
Жоншт уул	Jonsht uul	Ховд	Мөст
Жоншт уул	Jonsht uul	Ховд	Зэрэг
Жоншт уул	Jonsht uul	Завхан	Отгон
Жоншт уул	Jonsht uul	Төв	Баянцогт
Жоншт уул	Jonsht uul	Хөвсгөл	Тариалан
Жоншт уул	Jonsht uul	Сэлэнгэ	Хүдэр
Жоншт уул	Jonsht uul	Говь-Алтай	Жаргалант
Жоншт уул	Jonsht uul	Булган	Бугат
Жоншт уул	Jonsht uul	Ховд	Буянт
Жоншт уул	Jonsht uul	Говь-Алтай	Эрдэнэ
Жонштой уул	Jonshtoy uul	Хөвсгөл	Цагаан-Үүр
Жонштын Овоо уул	Jonshtyn Ovoo uul	Хөвсгөл	Жаргалант
Жонштын уул	Jonshtyn uul	Баянхонгор	Жаргалант
Жоншин ухаа	Jonshin uhaa	Төв	Арбулаг
Жоншт ухаа	Jonsht uhaa	Хэнтий	Галшир
Жоншны хоолой	Jonshny hooloy	Өмнөговь	Булган
Жоншны хоолой	Jonshny hooloy	Өмнөговь	Мандал-Овоо
Жоншны хөтөл	Jonshny hotol	Хэнтий	Биндэр
Жонштын хөтөл	Jonshtyn hotol	Төв	Баянцогт
Жоншт худаг	Jonsht hudag	Сүхбаатар	Уулбаян
Жонштын Ихэр худаг	Jonshtyn Iher hudag	Дорноговь	Дэлгэрэх
Жонштын худаг	Jonshtyn hudag	Дундговь	Өлзийт
Жонштын худаг	Jonshtyn hudag	Дорноговь	Дэлгэрэх
Жонштын худаг	Jonshtyn hudag	Говь-Алтай	Тайшир
Жонш булаг	Jonsh b-lag	Говь-Алтай	Тайшир
Жонштын говь	Jonshtyn govi	Дундговь	Өлзийт
Жонштын говь	Jonshtyn govi	Сүхбаатар	Уулбаян
Ар Жонштын гол	Ar Jonshtyn gol	Завхан	Алдархаан
Өвөр Жоншит гол	Ovor Jonshit gol	Завхан	Алдархаан
Жоншит жалга	Jonshit jalga	Завхан	Отгон
Жоншны нуруу	Jonshny nuruu	Өвөрхангай	Баянгол
Жонштын нуруу	Jonshtyn nuruu	Завхан	Алдархаан
Жонштын нуруу	Jonshtyn nuruu	Говь-Алтай	Тайшир
Жонштын нуур	Jonshtyn nuur	Дорноговь	Дэлгэрэх
Жоншит сайр	Jonshit sayr	Увс	Малчин
Жонштын сайр	Jonshtyn sayr	Говь-Алтай	Тайшир
Жонштын сайр	Jonshtyn sayr	Ховд	Чандмань

Жонштын таг	Jonshtyn tag	Архангай	Өндөр-Улаан
Жоншны тойром	Jonshny toyrom	Өвөрхангай	Баянгол
Жоншт толгод	Jonshit tolgod	Увс	Малчин
Жонштын толгод	Jonshtyn tolgod	Өвөрхангай	Нарийнтээл
Бух Жоншт толгой	Jonshtyn tolgod	Сүхбаатар	Уулбаян
Жонш толгой	Buh Jonsht tolgoi	Хэнтий	Батноров
Жонш толгой	Jonsh tolgoi	Хэнтий	Биндэр
Жонш толгой	Jonsh tolgoi	Архангай	Батцэнгэл
Жонш толгой	Jonsh tolgoi	Архангай	Ихтамир
Жонш толгой	Jonsh tolgoi	Архангай	Хашаат
Жоншит толгой	Jonshit tolgoi	Өвөрхангай	Баянгол
Жоншит толгой	Jonshit tolgoi	Дундговь	Говь-Угтаал
Жоншт толгой	Jonsht tolgoi	Дундговь	Өлзийт
Жоншт толгой	Jonsht tolgoi	Дундговь	Дэлгэрхангай
Жоншт толгой	Jonsht tolgoi	Дундговь	Баянжаргал
Жоншт толгой	Jonsht tolgoi	Дорноговь	Айраг
Жоншт толгой	Jonsht tolgoi	Говь-Алтай	Эрдэнэ
Жоншт толгой	Jonsht tolgoi	Сүхбаатар	Уулбаян
Жонштын Хүрэн толгой	Jonshtyn Huren tolgoi	Дорноговь	Дэлгэрэх

Дээрх “жонш” бүхий нийт нэрээс 20 нь доорх “Эдийн засгийн макро бүсүүдийн ашигт малтмалын зураг”-т тэмдэглэгджээ.

Мөн зургаас өмнө өгүүлсэн 3 бүсийг ажиглаж болох байна.



Эндээс бид жоншны гурван гол бүс, мөн “жонш” бүхий 72 газар нутгийн нэрийг доорх хүснэгтээс харах болно. Үүнд

Д/д	Бүс	Аймаг
1.	I	Увс (2), Хөвсгөл (4), Булган (2), Сэлэнгэ (1)
2.	II	Хэнтий (4), Сүхбаатар (4), Дундговь (6), Дорноговь (5)
3.	III	Ховд (4), Говь-Алтай (11), Баянхонгор (3), Өмнөговь (2)

Манай оронд хайлуур жоншны нийт 6 орд газар ажиллаж байгаа ба тэдгээрийн гурав нь юутай ч атугай жонш нэртэй газарт байрлаж байна. Үүнд :

Бэрхийн уурхай (Хэнтий, Батноров, Бух Жонш толгой)

Хажуу Улааны уурхай (Хэнтий)

Айрагийн уурхай (Дорноговь, Айраг, Жонш толгой)

Галшарын уурхай (Хэнтий, Галшар, Жонш ухаа)

Бор Өндөрийн уурхай (Хэнтий)

Энэхүү баримтаас харахад үнэхээр жоншны хоёр дахь бүс нь нөөцөөр илүү, мөн уурхайнууд ч уг бүсэд үйл ажиллагаа явуулж байна. Мөн энэ нь О. Сүхбаатарын “газар усны ихэнх нэр нь тухайн газрын газарзүйн онцлог, геологийн тогтоц, түүх соёл, зан заншлын уламжлал, ургамал амьтны тархац байдал, агуулж буй эрдэс баялгийг илэрхийлдэг. Үүгээрээ газар усны нэр нь мэдээллийн томоохон сан болж өгдөг” гэснийг⁵ давхар нотлож байна.

Иймд газар нутгийн нэр судлалыг цаашид улам хөгжүүлэн, түүнийг тал бүрээс нь судлах зайлшгүй шаардлагатай болох нь илэрхий байна.

Дүгнэлт:

Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (5 боть, 8 дэвтэр)-д орсон нийт 2674 ашигт малтмал эрдэс баялгаар нэрлэсэн газар нутгийн нэрээс энэхүү өгүүлэлд “жонш”-оор нэрлэсэн 72 газар нутгийн нэрийг судлан үзэв.

Монгол улсад ашиглаж байгаа хайлуур жоншны 6 орд газрын гурав нь “жонш” нэртэй газарт нээгдэн, олборлолтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Жонш бүхий 72 нэрийг ашигт малтмалын зурагт аймаг, сумаар нь харахад Монгол оронд буй жоншны 3 том бүстэй дүйж байна.

⁵ О.Сүхбаатар “Монголын газар усны нэрийн домог” УБ., 2001, 15-р тал.

Номзүй :

Дэлхийн банк “Уул уурхай: Ирээдүй таны гарт”, УБ., 2004

Намнандорж. О “Онож өгсөн газар усны нэр” ШУА, УБ., 1979, №4

“Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь” (Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан /1970-1980/, 5 боть, 8 дэвтэр), УБ., 2005

“Монголросцветмет нэгдэл” 25 жилийн ойд, УБ., 1998

“Монголросцветмет нэгдэл” 30 жилийн ойд, УБ., 2003

Равдан. Э “Монгол газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа” ., УБ, 2004

Содов. Ж “Газарзүйн нэр томъёог зөв хэрэглэе” ШУА, УБ., 1979, №4

Сүхбаатар. О “Монгол газар усны нэр мэдээлэлийн сан болох нь”, Mongolica. Vol 14(35) УБ., 2004

Сүхбаатар. О “Монголын газар усны нэрийн домог” УБ., 2001

Түдэв. Л “Газрын нэр судлалын шинэ ололт”, Дал сонин, 2005, №205/51

Шагдар. Ш “Монголын газарзүйн нэрийн товч толь бичиг”, УБ., 1978

Шагдар. Ш “Монголын газар усны нэрэн дэх тэмдэг нэрийн тухайд” ШУА, УБ., 1979, №3

Түлхүүр үг: Монгол газар нутгийн нэр, Ашигт малтмал, Жонш, Бүс

Abstract

**THE GEOGRAPHIC PLACES NAMED RELATIVELY WITH “SPAR”,
THEIR LOCATIONS AND CONTENTS OF THEIR TOPONYMS**

The toponyms created relatively to the natural resources of Mongolia from the “Classified Dictionary of Mongolian Toponyms” (compiled by E.Ravdan, UB, 2004, 5 volumes, 8 parts, with a CD enclosed) served a background for this research. This article deals with 72 toponyms which include the name “spar” and 20 of them are registered in the “Map of Natural Resources in the Macro-economical Zones”. These toponyms cover in general the three basic spar basins in the country. Three of the 6 mines currently functioning in Mongolia are located in the places with the names including the word “spar”.